



ЧИНГЭЛТЭЙ ДУУРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

“Чингэлтэйд үйлдвэрлэв-2028”  
арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шинэ технологи бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг өргөтгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засагт жижиг дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх зорилго бүхий “Чингэлтэйд үйлдвэрлэв-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны  
өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт

## “ЧИНГЭЛТЭЙД ҮЙЛДВЭРЛЭВ-2028” АРГА ХЭМЖЭЭ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас үндэсний үйлдвэрийг дэмжих чиглэлээр жижиг дунд үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж буй энэ цаг үед Монгол хүн бүрийг үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлогыг иргэн бүрд суулгах, нөлөөллийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ үүсээд байна.

Үндэсний статистикийн хорооны бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 83 хувь нь, нийт ажиллах хүчиний 72 хувь нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 17,8 хувь, экспортын 2,3 хувийг жижиг, дунд үйлдвэрийн салбарт үйлдвэрлэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Эдийн засгийн бодлогын багцын **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн 3.3.13 дахь заалтыг** хэрэгжүүлж импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо худалдаа үйлчилгээний салбарын татвар эрх зүй, бизнесийн таатай орчин бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү арга хэмжээг боловсрууллаа.

Дүүргийн хувьд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч ААНБ, иргэдийг түлхүү хөгжүүлж үйлдвэрлэгч болгон эдийн засгийн өсөлтөд бодит нэмэр оруулж иргэдийн орлогыг нэмэгдүүлэх гол зорилго юм. Үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явц амжилттай явагдаж байгаа боловч бараа бүтээгдэхүүний чанар технологи, сав баглаа боодлыг сайжруулах, тухайн бүтээгдэхүүнээ олон нийтэд хүргэх, гадаад, дотоодын зах зээл борлуулалт хийх суваг цөөн байгаа учир дээрх боломжуудыг нэмэгдүүлэх нь “Чингэлтэйд үйлдвэрлэв-2028” арга хэмжээг боловсруулах үндэслэл болж байна.

### Хоёр. Арга хэмжээний зорилго

Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, шинэ технологи бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг өргөтгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засагт жижиг дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэхэд арга хэмжээний зорилго оршино.

### Гурав. Арга хэмжээний зорилт

**Зорилт 1.**Нэмүү өртөг шингэсэн бүтээмж өндөртэй үйлдвэрлэлд суурилсан кластерын системийг хөгжүүлж жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг бүртгэлжүүлэн бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулна.

1.1.Үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, стандарт хаяг логотой болгох, иргэд аж ахуй нэгжид сургалт сурталчилгаа хийх;

1.2.Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, хөдөлмөр хөнгөвчилсөн дэвшилтэт технологийг таниулах, мэдээ мэдээллээр хангах (Оёдол модон эдлэл, арьсан эдлэл)-ийн сургалтын танхим бий болгох;

1.3.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйл ажиллагааг цахим платформоор ажиллуулж, идэвхжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

**Хүрэх үр дүн:** Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид чанар стандартын нэгдсэн ойлголттой болж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний оюуны өмчийн эрхээр хамгаалуулсан байна. Мэдээллийн сан бий болж иргэд сайн дурын даатгалд хамрагдаж татвар төлөгчөөр бүртгэгдэнэ.

**Зорилт 2.**Жижиг, дунд үйлдвэрлэлийг чадавхжуулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, “Жижиг, дунд Үйлдвэрийг дэмжих төв”-өөр дамжуулан сургаж хөгжүүлэх, бизнес эрхлэх, төсөл боловсруулах, сургалт зөвлөгөө мэдээллээр хангана.

2.1.Үйлдвэр эрхлэгчдийг санхүү, зээлийн үйлчилгээнд зуучлах, төсөл хөтөлбөр боловсруулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх олон талт сургалтыг зохион байгуулах;

2.2.“Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын борлуулалтын цэгийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлдвэрлэл худалдааны гудамж байгуулах;

2.3.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн саналд үндэслэн дэмжлэг үзүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлagnаж ажиллах;

**Хүрэх үр дүн:** Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн нэг удаад бойжих хүчин чадлыг нэмэгдүүлж, иргэд бизнес эхлэх шинэ санаа бий болж хөдөлмөр эрхлэх анхан шатны мэдлэг мэдээлэлтэй болно.

**Зорилт 3.**Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж, зээл олгоход нь дэмжлэг үзүүлнэ.

3.1.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үйлдвэрлэлээ явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зөвөрийн ажлын байр болон түрээсийн хөнгөлөлттэй ажлын байранд хамрагдуулж ажиллах;

3.2. Гадаадын хот дүүргүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн, туршлага солилцож, үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон талт үйл ажиллагааг зохион байгуулах;

**Хүрэх үр дүн:** Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгч иргэд аж ахуй нэгж байгууллагыг зээл тусламж, хамтын ажиллагааны хөтөлбөрт хамруулснаар эргэлтийн хөрөнгө болон санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэлээ өргөтгөн, шинээр ажлын байр бий болгох, эрүүл аюулгүй ажлын байранд хөдөлмөрлөх боломжоор хангагдана.

**Зорилт 4.Жижиг,** дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тулхуу хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно.

4.1. Үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих, туршлага солилцох зорилгоор хилийн дагуух худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс, гуравдагч орны зах зээлд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллагын бараа бүтээгдэхүүнийг борлуулах, худалдааны цэгүүд бий болгох талаар судлах, түншлэл тогтоох;

4.2. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг үе шаттай нэмэгдүүлэх;

**Хүрэх үр дүн:** Үйлдвэрлэгчдийн хамтарсан багийг олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулсан байна. Төрийн байгууллагын худалдан авалт, зах зээлийн эрэлтэд тулгуурласан бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болно.

#### **Дөрөв.Арга хэмжээний хугацаа, санхүүжилт**

4.1. Арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2. Арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- ✓ Улсын болон орон нутгийн төсөв
- ✓ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө
- ✓ Орон нутгийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгө
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө
- ✓ Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- ✓ Бусад эх үүсвэр

#### **Тав.Арга хэмжээний удирдлага зохион байгуулалт, хяналт**

5.1. Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:

- ✓ Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
- ✓ Чингэлтэй дүүргийн Жижиг дунд Үйлдвэрийг дэмжих төв

- ✓ Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- ✓ Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс
- ✓ Дүүргийн 1-24 дүгээр хороод

**5.2.Арга хэмжээний хэрэгжилтийн явцад дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороод хяналт тавьж болно.**

**Зургаа.Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт**

**6.1.“Чингэлтэйд үйлдвэрлэв-2028” арга хэмжээний үр дунд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид хамтран шинэ технологи нэвтрүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулж бараа бүтээгдэхүүний борлуулалтыг эрчимжүүлж, өрхийн орлого, шинэ ажлын байрны тоог нэмэгдүүлсэн, хадгалсан байдлаар хэмжигдэнэ.**

**Шалгуур үзүүлэлт:**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин			
				2025 он	2026 он	2027 он	2028 он
1	2	3	4	5	6	7	8
<b>Зорилт 1.Нэмүү өртөг шингэсэн бүтээмж өндөртэй үйлдвэрлэлд суурилсан кластерийн системийг хөгжүүлж, жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг бүртгэлжүүлэн, бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулна.</b>							
1.1	Дүүргийн иргэд, аж ахуйн нэгж бүтээгдэхүүний нэр хаяг, логотой болгох талаар зохион байгуулсан сургалт	Тоо	150	40	45	50	65
1.2	Оёдол, модон эдлэл, арьсан эдлэлийн танхимд хөдөлмөр хөгжүүлжүүлэх дэвшилтэй таниулах хамрагдах үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	Тоо	-	20	25	30	35
1.3	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйл ажиллагааг цахим платформоор идэвхжүүлэх аж ахуйн нэгжийн тоо	Тоо	30	-	40	50	60

Зорилт 2.Жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, "Жижиг дунд Үйлдвэрийг дэмжих төв"-өөр дамжуулан сургаж хөгжүүлэх, бизнес эрхлэх, төсөл боловсруулах, сургалт зөвлөгөө мэдээллээр хангана.

2.1	Үйлдвэр эрхлэгчдийг санхүү, зээлийн үйлчилгээнд зуучлах, төсөл хөтөлбөр боловсруулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх олон талт сургалт/ хамруулах үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	Too	6/200	2/50	2/55	2/60	2/65
2.2	Байнгын борлуулалт хийхээр байгуулсан гудамжны тоо	Too	1	-	-	1	1
2.3	Дэмжлэг үзүүлэх олон талт үйл ажиллагаа	Too	-	40	45	50	55

Зорилт 3.Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж, зээл олгоход нь дэмжлэг үзүүлнэ.

3.1	Зөөврийн болон түрээсийн ажлын байрны тоо	Too	123	124	125	126	127
3.2	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	Too	30	35	40	45	50

Зорилт 4.Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно

4.1	Гадаад улсад туршлага солилцох, бараа бүтээгдэхүүн борлуулах үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	Too	20	20	25	30	35
4.2	Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд худалдан авалт хийх үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	Too	-	3	6	9	12

Үр дүн:

- Үйлдвэрлэлийн инновацад суурилсан кластерийг дагаж бий болсон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна.
- Дэмжлэгт хамрагдсан болон шинээр бий болсон ажлын байрны тооны өсөлт, салбар бүрээр тодорхой гарч ажлын байрны тоо нэмэгдсэн байна.
- Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна.
- Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг хэвшүүлж жижиг, дунд өрхийн үйлдвэр эрхлэгчдийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлэн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, татвар төлөгчийн тоо өссөн байна.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, борлуулалтын хэмжээ өссөн байна.
- Шинэ санаачилга, техник технологи, инновацыг дэмжсэнээр жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирч, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлсэн байна.

#### **Долоо.Хяналт – үнэлгээ, үр дүнг тайлагнах явц**

Арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлagnan, хэрэгжилтийг ханган ажиллана.